



ГАРЧИГ

- 2–3 Бодлогын нийтлэл
- 4–5 Зохицуулалтын мэдээ
- 6–8 Дэлхийн мэдээллийн технологийн салбарт гарах боломжтой
- 9–11 Финтек ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТЭД НӨЛӨӨЛӨХ нь
- 14–15 Хэрэглэгч
- 16 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
- 17–18 Олон улсын зах зээлийн мэдээ
- 19 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ФИНТЕКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА:



Эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй 536 ББСБ нь давхардсан тоогоор 21,486 хувьцаа эзэмшигчтэй, 308 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 3,713 ажилтантайгаар Монгол Улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.3 сая харилцагч, 748.3 мянган зээлдэгчид санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд харилцагч, зээлдэгчдийн үзүүлэлтүүд 3–4 дахин нэмэгдсэн байна. Ялангуяа харилцагч, зээлдэгчдийн тоон үзүүлэлтийн хувьд ингэж нэмэгдсэн нь технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ ББСБ–ууд үйл ажиллагаандаа өргөнөөр нэвтрүүлэн ашиглаж эхэлсэнтэй холбоотой.

Монгол Улсын санхүүгийн салбарт тэр дундаа банк бус санхүүгийн салбарын хөгжил нь финтек буюу санхүүгийн технологитой салшгүй холбоотойгоор тодорхойлогдож байна. Финтек нь өргөнөөр нэвтэрч байгаатай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс энэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлж буй ББСБ–удын хөгжлийг бодлогоор дэмжин ажиллаж байгаа бөгөөд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 22 ББСБ дэвшилтэд технологид тулгуурлан аппликэйшн ашиглан зээл олгож байна.

Банк бус санхүүгийн салбарт энэхүү шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд техник технологийг ашиглаж барьцаа хөрөнгө шаардахгүй, богино хугацаатай, бага хэмжээний зээлийг тусгай зөвшөөрөлтэй, төрийн зохицуулалттай, мэргэжлийн ББСБ–аас хялбар, түргэн шуурхай, нөхцөл багатайгаар авч байгаа нь цаашид барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбардын зах зээлийг хумих чухал ач холбогдолтой.

Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ санал болгож байгаа ББСБ–уудын зээлийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин нь салбарын дунджаас 0.9 пунктээр өндөр буюу 3.8 хувьтай байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаа их хэмжээний гарааны хөрөнгө оруулалт шаарддагтай холбоотой юм. Цаашид эдгээр ББСБ–ууд оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөж, салбарын өрсөлдөөн нэмэгдсэнээр зээлийн дундаж хүү буурах боломжтой.

Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн салбарт нэвтрээд буй финтек зээлийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор Азийн Хөгжлийн Банкны (АХБ)–ны санхүүжилттэйгээр хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн зах зээлийг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд олон улсын болон дотоодын зөвлөхтэй хамтран банк бус санхүүгийн байгууллагын финтек зээлийн судалгаа, финтек зээлийн харилцагчдын судалгаа, финтекийн зохицуулалтын орчны судалгааг тус тус хийн финтекийн бүтээгдэхүүний журам, зохицуулалтыг боловсруулан гаргаж, ББСБ–уудаа хөгжлийн дараагийн шатанд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- Засгийн IV байр, Бага тойруу–3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- +976-51-264444
- press@frc.mn
- www.frc.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

Ургэлжлэл 2-р нүүрт >>



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ

Таавар, валют, эдийн засгийн хувьсагч, санхүүгийн хэрэгсэл гэх зэрэг суурь болж байгаа хөрөнгөөсөө үнэ нь хүчтэй хамаарч байдаг санхүүгийн хэрэгсэл бөгөөд фьючерс гэрээ, форвард, своп, опцион гэн төрлүүдтэй.



DERIVATIVE

A financial instrument, the price of which has a strong relationship with an underlying commodity, currency, economic variable or financial instrument. The different types of derivatives are futures contracts, forwards, swaps and options.

Эх сурвалж:

Банк санхүүгийн тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ФИНТЕКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Эхлэл 1-р нүүрт >>

ББСБ-ын финтек зээл, харилцагчдад хийсэн судалгаанаас харахад финтек зээл нь технологийн эрин үед зайлшгүй байх шаардлагатай санхүүгийн бүтээгдэхүүний нэг болох тул санхүүгийн салбарт маш хурдацтай нэвтэрч байгаа нь харагдаж байна. Одоогоор ББСБ-уудын зүгээс

ижил төрлийн шаардлага, зохицуулалтыг тавьж өгснөөр энэхүү асуудал шийдэгдэх боломжтой болох юм.

Монгол Улсын орчинд хийсэн судалгаанаас үзэхэд финтек зээлийн аппликэйшнийг бүрэн цахимжуулсан



финтектэй холбоотой зарим эрх зүйн орчин, төрийн зохицуулалт тодорхой биш учраас хөгжүүлэлтийн хувьд хүлээлт үүсээд байна.

Финтек зээлийг зах зээлд гарган үйлчилгээ үзүүлж буй ББСБ-уудийн удирдлагатай хийсэн ярилцлагаас харахад зах зээл дээр тусгай зөвшөөрөл, төрийн тусгайлсан зохицуулалт байхгүйгээр барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд /ломбард/ финтек зээлийн аппликэйшн хөгжүүлэн иргэдэд зээл олгож байгаа тохиолдлууд гарсаар байна. Гэтэл судалгаанаас харахад финтек зээлийн үйл ажиллагаа нь зайлшгүй төрийн зохицуулалттай байх хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрэхээр байна. Санхүүгийн хэрэглэгчдэд хүргэж байгаа нэг төрлийн санхүүгийн үйлчилгээнд

финтек бүтээгдэхүүн гэж үзэхэд учир дутагдалтай байна.

Нөгөө талаас монгол улсад цахим гарын үсгийн баталгаажуулалтын хууль эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгаагаас шалтгаалан финтек зээлийн үйлчилгээ үзүүлж буй ББСБ-уудын хувьд харилцагчтай байгуулах гэрээг заавал биеэр ирж байгуулахыг шаардаж байна. Коронавируст халдвартай /Ковид-19/ холбоотойгоор цахим гэрээг хийж эхэлсэн ч цаашид зээлийн эрсдэл гарсан тохиолдолд эрх зүйн орчин тодорхойгүйгээс хууль, шүүхийн байгууллагад хандахад асуудал үүсэх магадлал өндөр байна.

Финтекийн зээлийн үйлчилгээ эрхлэж буй ББСБ-уудын нийт харилцагчдын 44.7 хувь нь хүү, шимтгэл боломжийн, 34.4 хувь нь бага зэрэг өндөр, 4.6 хувь

нь хүү шимтгэл бага гэсэн нь одоогийн финтек зээлийн үнэ нь зах зээлийн нөхцөл байдал, харилцагчийн хүлээлттэй ойролцоо тогтоогдсон гэдгийг харуулж байна. Нийт харилцагчдын 54.3 хувь нь 1 сараас доош хугацаатай зээл авсан бол 6.3 хувь нь 12 сараас дээш хугацаатай авсан байгаа нь финтек зээлийн хугацаа уламжлалт зээлтэй харьцуулахад маш богино, харилцагчдын 4.6% нь 3 сая төгрөгөөс дээш хэмжээний зээл, 24.7 хувь нь 1 саяас 3 сая төгрөг хүртэл зээл авсан байгаа нь финтек зээлийн хэмжээ бага дүнтэй байгааг харуулж байна. Зээлийн хэмжээ, хугацаа бага байгаа нь харилцагч нэгэн зэрэг олон байгууллагаас зээл авах эрсдэлийг үүсгэх магадлалтай нь энэхүү судалгааны дүнгээс харагдаж байна.

Мөн судалгаанд харилцагчийн санхүүгийн боловсрол тэр тусмаа цахим бүтээгдэхүүнийг ойлгох, аппликэйшнтэйгээ ажиллах мэдлэг чадвар дутмаг, харилцагч нэгэн зэрэг олон аппликэйшнээс зээл авснаар өрийн дарамтад орох, финтекээр зээл авсан зээлдэгчийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэх нийлүүлэлт дутмаг байгаагаас цахим зээл ба өөр төрлийн зээл давхар авах зэрэг финтек зээлийн үйлчилгээнд тулгарч буй асуудлыг тодорхойлсон байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийнхээ хүрээнд харилцагчийг өрийн дарамтад оруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Банк бус санхүүгийн байгууллагын финтек бүтээгдэхүүнийг бүртгэх, түүнд хяналт тавих түр журам”-ыг боловсруулж байна. Энэхүү

зохицуулалтын хувьд банк бус санхүүгийн үйлчилгээг финтекээр дамжуулан эрхлэх ББСБ-д болон санхүүгийн технологийн үйлчилгээнд тавигдах шаардлага, бүртгэл, харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад тавигдах нөхцөл, үйл ажиллагаандаа мөрдөх зарчим, хариуцлага зэргийг тусгасан. Мөн журмын төсөлд дээр дурдсан судалгаа, дүгнэлт, зөвлөмжийг тусган Монгол Улсад анхны финтек зээлийн үйл ажиллагааны зохицуулалтыг бий болгохоор ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос финтек зээлийн зохицуулалтыг бий болгосноор техник, технологийг ашиглаж, онлайн зээлийн үйлчилгээ хурдацтай хөгжихийн хэрээр тухайн үйлчилгээг эрхэлж буй санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулалтад оруулж, иргэдийг өрийн дарамтад орох, иргэдийн мэдээллийн аюулгүй байдал алдагдах зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооноос олон улсын финтекийн зохицуулалтын давуу талыг шингээн өөрийн орны онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зээлийн хүү буурах, цаг хугацаа, мөнгө хэмнэх иргэдийг өрийн дарамтад өртөхөөс сэргийлэх зэрэг үр дүнгүүдийг бий болгох, техник технологийн эрин үед цаг үеэ олсон чухал алхам болно.

Цаашид банк бус санхүүгийн финтек зээл, тэдгээрийн харилцагчдаас авсан судалгааны үр дүнгээс харахад финтек зээлийн бүтээгдэхүүн маш хурдацтайгаар хөгжих нь тодорхой харагдаж байна.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛО



Монгол Улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдыг хамгаалах, эдийн засгийн эргэлт, гадаад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх болон олон улсын стандартад нийцүүлэх ажлын

хүрээнд Засгийн газраас Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

ВХҮҮ-ийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, бүртгэх ажил нь инновацийг дэмжих, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Хууль батлагдсанаар талуудын эрх, үүрэг, гэрээний стандарт тодорхой болж иргэд, олон нийт мэдлэг мэдээлэлтэйгээр тус салбарын үйл ажиллагаанд оролцож хохирлоос урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Х.Булгантуяа, Б.Энхбаяр, Г.Амартүвшин нарын бүрэлдэхүүнтэй Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны удирдлагуудтай уулзаж төрийн санхүүгийн зохицуулагч байгууллагуудын байр суурийг сонслоо. Тус хуралд Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл оролцон хуулийн төсөлтэй холбоотой бусад мэдээллүүдийг өгсөн.



Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албанаас виртуал хөрөнгийн салбарын олон улсын туршлага, бодлого зохицуулалт, хандлага, Монгол Улсын виртуал хөрөнгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар танилцууллаа.



Хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын гишүүд болон оролцогчид нээлттэйгээр санал солилцон асуулт, хариулт өрнүүлж цаашид тус хуулийн төслийг иргэд, олон нийт, бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг

хамгаалсан, тэдгээрийн үйл ажиллагаанд цахим шилжилтийг дэмжсэн, олон талт эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн байхаар боловсруулах чиглэлд хамтран ажиллахаар талууд харилцан санал нэгдсэн байна.

ХҮНДЭТГЭЛИЙН ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛО

Инновацийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т “Гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 995 дугаар тогтоолоор баталсан “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулан олон нийтээс санал авч байна.

Иймд салбарын оролцогчид болон иргэд Та бүхэн тогтоолын төсөлтэй танилцаад саналаа smd@frc.mn цахим хаягаар ирүүлж, хамтран ажиллахыг хүсье.

ХҮНДЭТГЭЛИЙН ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛО



“АПУ” ХК-ийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1 их наяд төгрөгт хүрсэнтэй холбогдуулж хүндэтгэлийн цан цохих ёслолын арга хэмжээ өнөөдөр боллоо. Уг арга хэмжээнд УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай, “АПУ” ХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг болон холбогдох албаны бусад хүмүүс оролцсон юм.



Цан цохих ёслолыг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хэлсэн үгэндээ “Хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэлтэй, ТОП-20 индексийн багцын тэргүүн байранд жагсдаг “АПУ” ХК-ийн хувьцааны зах зээлийн үнэлгээ өнөөдөр 1,210,728,232,277 төгрөгт хүрснээр Монгол Улсад анх удаа 1 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй компани бий болсон түүхэн үйл явдал тохиож байна. Дэлхий нийтийг хамраад буй коронавируст халдварт цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт буурч, нийгэм, эдийн засагт гарч буй сөрөг нөлөөнөөс шалтгаалж иргэд, аж ахуйн нэгжийн орлогын түвшин буурсан нь дотоодын хөрөнгийн зах зээлд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хэмжээ, хөрвөх чадвар буурахад хүргэсэн амаргүй цаг үетэй бид нүүр тулж байсан. Гэсэн ч энэ оны хагас жилийн байдлаар хөрөнгийн зах зээлд хувийн хэвшлээс компанийн бонд, анхны арилжааны зориулалттай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, биржээр арилжаалагддаг хамтын хөрөнгө оруулалтын сан зэрэг шинэ бүтээгдэхүүнийг гаргаснаар хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.6 дахин өссөн үзүүлэлттэй гарсан нь Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээ, хөрөнгийн зах зээлийн орчинд мэргэжлийн байгууллага, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын нягт хамтын ажиллагааны үр дүн юм.

Тодруулбал, УИХ-аас Банкны тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар 2022 оны 6 дугаар сард багтаан банкны системд нөлөө бүхий банкууд олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар нээлттэй ХК болох томоохон ажил хүлээгдэж байгаа бөгөөд салбарын чухал хуулиуд болох Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудад нэн шаардлагатай байгаа нэмэлт, өөрчлөлтийг оруулж, УИХ-ын намрын чуулганаар батлуулахаар ажиллаж байна.

Мөн хөрөнгийн зах зээлд оролцогчдын дунд ихээхэн хүлээлтийг үүсгээд байсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг Хорооноос саяхан баталснаас гадна нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, үүнтэй холбоотой гарах зардал, өртөг буурч, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд, андеррайтерууд чадавхиж тэдгээрийн оролцоо нь нэмэгдэх, компанийн бондыг үе шаттайгаар хэсэгчлэн гаргах боломжтой болсны зэрэгцээ цоо шинэ бүтээгдэхүүн болох “Ногоон бонд” гаргах нөхцөл бүрдлээ” хэмээн онцолсон юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРТ ДЭВШИЛ ГАРЧ БАЙГААД БАЯРТАЙ БАЙГААГА ИЛЭРХИЙЛЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханыг хүлээн авч уулзаж, санхүүгийн салбарын үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан уулзалтын эхэнд цар тахлаас хамааран эдийн засгийн идэвхжил суларсан ч санхүүгийн салбар 4.2 пунктээр өсөж, ДНБ-ий 17.5 хувьд хүрсэн талаар мэдээлэл хүргэхийн зэрэгцээ Хорооноос одоо болон цаашид хийж, хэрэгжүүлж буй ажлуудынхаа талаар товч танилцуулсан юм. Тухайлбал, банкуудыг хувьцаат компани болгох ажлын явцын талаар мэдээлэл өгч, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 11 банкны 9 нь хувьцаат компани болох төлөвлөгөөгөө Монголбанк болон СЗХ-нд ирүүлсэн бөгөөд ирэх есдүгээр сарын 1-ний өдөр гэхэд банкуудын төлөвлөгөө батлагдаж, хувьцаат компанийн хэлбэртэй болох үйл ажиллагаа эхэлнэ гэдгийг хэллээ. Тэрбээр мөн санхүүгийн салбарыг банк төвтэй бус болгох, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг хувьцаат компанид шилжүүлэх зэрэг ажлуудыг хийж, хэрэгжүүлэх шаардлагатай байгааг онцлов.



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх энэ үеэр банк, санхүүгийн салбарын реформыг зайлшгүй хийх шаардлагатай учраас Ерөнхий сайдаар ажиллахдаа энэ ажлыг эхлүүлсэн нь эхнээсээ хэрэгжиж, хууль

тогтоомжуудад өөрчлөлт оруулан зохих түвшинд дэвшил гарч байгаад баяртай байгаагаа илэрхийллээ. Түүнчлэн банкны реформыг хийхдээ дэлхий нийтийн хөгжлийн жишгээр олон нийтийн оролцоог сайтар хангах, ил тод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, баялаг бүтээгчдийг дэмждэг банк, санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд Санхүүгийн зохицуулах хорооноос онцгой анхаарч ажиллахыг хүслээ.

Цаашилбал, өрхийн санхүүгийн чадамжаас давсан, өр, зээл үүсгэсэн харилцааг зохицуулах, хэрэглэгчдийг хохироосон өндөр хүүтэй зээл олголтын эсрэг хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатайг онцлоод бүрэн эрхийнхээ хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм.

БАЙР СУУРЬ

ДЭЛХИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ ГАРАХ БОЛОМЖТОЙ

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос гишүүн болон харилцагч байгууллагуудынхаа дунд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн энэ оныг “Хүртээмжтэй санхүүгийн жил” болгон зарласан. Энэ хүрээнд салбарын компаниуд хэрхэн ажиллаж буй талаар цуврал ярилцлага хүргэж байгаа билээ. Энэ удаагийн зочноор “ЛэндМН ББСБ” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Удвалыг уриллаа.

Банк бус санхүүгийн байгууллагын хөгжил, ирээдүйд ямар түвшинд хүрэх боломжтой вэ гэдгээс ярилцлагаа эхэлье?

Манай улсад 530 орчим банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Хүртээмжийн хувьд банк бусынхан нийгмийн хэрэгцээнд тулгуурлан хөгжиж байгаа гэж боддог. Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар манай салбараар үйлчлүүлдэг харилцагч гурван сая давсан тоон судалгаа бий. Зөвхөн манай “Лэнд МН”-ийн хувьд бүртгэлтэй харилцагч 900 мянгад хүрсэн байна. Харин зээлийн гэрээтэй 177 мянган харилцагчтай болжээ. Эндээс харвал харилцах хүрээ тэлэхээс гадна хүртээмжтэй үйлчилгээ үзүүлж байгаагийн илрэл гэж хардаг.

Нөгөөтээгүүр хурдацтай хөгжиж байгаагийн нэг шалтгаан технологид суурилсан үйлчилгээ гэж болно. Тэгэхээр цаашид технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг харилцагч, үйлчлүүлэгчдэд хүргэх нь бидний хөгжлийн давуу тал болох учиртай. Яагаад гэвэл, цаг хугацаатай уралдан хүмүүст чирэгдэл багатайгаар үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байна.

Мөн түүнчлэн зохицуулах байгууллага, харилцагч байгууллагуудтай хэрхэн чирэгдэлгүйгээр хамтарч ажиллах вэ гэдэг чухал. Түүнээс гадна харилцагчдын санхүүгийн боловсролын асуудлыг орхигдуулж болохгүй. Ирээдүйд банк бус санхүүгийн байгууллага илүү тархацтай хөгжихийн зэрэгцээ технологид суурилсан үйлчилгээг түлхүү үзүүлдэг болно гэж хардаг.

Танай салбар технологийн дэвшлийг түлхүү ашигласнаар гарах давуу талыг юу гэж харж байна вэ?

Технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлснээр өрсөлдөөний давуу тал болно шүү дээ. Ингэснээр бүтээгдэхүүн үйлчилгээ болон хэрэглэгчид очиж байгаа үйлчилгээний чанар илүү сайн болох юм. Эцсийн дүндээ финтекийн хөгжил, технологийн

дэвшил нь хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг бий болгож байгаа хэрэг.

Монголчуудын хувьд зээлийн эргэн төлөлтөд хайнга ханддаг шүү дээ. Магадгүй санхүүгийн сахилга бат сул байгаагаас үүдэлтэй ч гэлцдэг. Энэ нь санхүүгийн боловсролтой шууд холбоотой гэдгийг мэргэжилтнүүд ярьсаар байгаа. Таны бодлоор?

Манай компани анх гар утасны аппликэйшн ашиглан барьцаагүй зээл авах үйлчилгээг эхлүүлсэн. Ингэхдээ тухайн хүний мэдээлэлд үндэслэн зээлийн эргэн төлөлтийн магадлалыг нь тооцоолдог. Тухайн гар утасны аппликэйшнээр дамжуулан зээл олгох нь өөрөө шинэ зүйл байлаа шүү дээ. Гэхдээ энэ алхам өнөөдрийн өөрчлөлтийг авч ирсэн гэж боддог. Магадгүй хүмүүсийг санхүүгийн сахилга баттай байхад сургасан гэхэд эргэлзэхгүй байна.

Харин санхүүгийн боловсролын тухайд цаашид илүү анхаарлаа хандуулах ёстой. Ингэхдээ эдийн засгийн мэдээллийг уншиж судлахаас илүүтэй хувь хүн өөрийн санхүүгээ зөв удирдаж, зарцуулж сурахад анхны мэдэгдэхүүнийг олгоход орших болов уу. Санхүүгийн боловсролыг хүүхэд байхаас нь төлөвшүүлэх хэрэгтэй. Одоогийн түвшинд зээлийн мэдээллийн санд бүртгэж байгаа нь хувь хүнийг санхүүгийн сахилга батад суралцах нэг хөшүүрэг юм. Тухайн хүн зээлийн эргэн төлөлтөд асуудал үүсгэсэн талаарх мэдээлэл дараа дараагийн санхүүгийн байгууллагуудтай харилцахад суурь мэдээлэл болж зээл олгох эсэхийг шийдвэрлэхэд голлох нөлөө үзүүлнэ. Учир нь тухайн банк, банк бус болон бусад зээл олгох байгууллагын эрсдэлийг хаах нэг үзүүлэлт болж өгнө.

Нөгөөтээгүүр финтек салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудад гол шалгуур нь тухайн зээлдэгчийн санхүүгийн сахилга баттай эсэх мэдээлэл чухал байдаг.

“ЛэндМН” зах зээлд нэвтэрч байх үед технологид суурилсан

учраас бодит ажлын байр төдийлөн гарахгүй нь гэсэн ойлголт үүсэж байсан. Гэхдээ энэ нь хэт өрөөсгөл байсныг цаг хугацаа харуулж байна л даа?

–Цар тахлын үед манайх нэг ч ажлын байрыг цомхотгоогүй, хадгалж үлдсэн. Одоогоор 100 гаруй ажилтантай. Банк санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудтай харьцуулахад зөвхөн нийслэлд төдийгүй улс орон даяар үйлчилгээ үзүүлж байгаа нь бидний давуу тал. Гэхдээ тэр хэрээр салбар байгуулж ажлын байр нэмэгдүүлж байгаа юу гэвэл, үгүй. Энэ бол финтек салбарын нэг онцлог.

Өнөөдрийг хүртэл 900 мянган харилцагчтай болсон нь цахим технологийн дэвшлийг ашиглан хүн бүрт хүрч үйлчилсний үр дүн. Тэгэхээр хүртээмжийн хувьд илүү олон байгууллага, хүнд хүрсэн хэдий ч салбар байгуулж ажлын байр нэмсэн нь бага. Хамгийн гол нь үндсэн үйл ажиллагаа болох технологи хөгжүүлэх зэрэг финтекийг хөдөлгөдөг ажлыг хийх нарийн мэргэшсэн боловсон хүчнээр ажлаа явуулж байгаа.

“Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо” энэ оныг “Санхүүгийн хүртээмжтэй жил” болгон зарласан байна лээ. Энэ хүрээнд ямар ажлууд хийж байгаа вэ?

Хүртээмжтэй санхүү гэдэг нь олон хүнд хүрч үйлчлэх юм. Дэвшилтэт технологид суурилсан гар утасны аппликэйшнийг ашиглан орон зайг үл хамааран санхүүгийн хэрэгцээгээ богино хугацаанд хангах боломжтой юм. Тиймээс бид орон нутагт байгаа харилцагчиддаа чирэгдэлгүй, шуурхай үйлчлэхийг чухалчилдаг. Энэ хүрээнд гар утасны аппликэйшн ашиглан манайд бүртгүүлсэн харилцагчидтай гэрээ байгуулахдаа тухайн орон нутагт байгаа нотариатын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Мөн түүнчлэн зээлийн үйлчилгээ гэхээс илүү төлбөр тооцоог хялбаршуулах зорилгоор “SuperUp” гэдэг аппликэйшнийг хөгжүүлэн ажиллаж байгаа. Бид хэрэглэгчдэд илүү шуурхай, энгийн үйлчилгээ үзүүлэхийг зорьж байна.

Банк бус санхүүгийн байгууллагад хөрөнгө оруулалт татах нь тулгамдсан асуудлын нэг. Танай компани хөрөнгийн захад бүртгэлтэй, үйл ажиллагаа нь нээлттэй байдаг учраас хувьцаа болон бонд гаргах замаар хөрөнгө босгож байна шүү дээ. Олон нийтээс хөрөнгө оруулалт татсаны давуу болон сөрөг тал юу байдаг вэ?

Хөрөнгө оруулагчид тухайн компани ирээдүйд хэр хөгжих вэ? Ашиг олж чадах болов уу гэдгийг нь харж хувьцаа болон бонд худалдан авна шүү дээ. Анх манай компанийг хөрөнгийн захад гарч байх үетэй харьцуулахад финтект суурилсан үйлчилгээг хүмүүс ойлгодог болжээ. Тодруулбал, анх цөөхөн харилцагчтай байсан бол одоогоор нийт 900 орчим тэрбум төгрөгийн зээл гаргасан байна. Зээлийн дундаж хэмжээг харвал 200–300 мянган төгрөг байдаг. Өөрөөр хэлбэл, хүнд богино хугацааны хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байгаа юм.

Нөгөөтээгүүр хөрөнгө оруулалт татах, IPO, нээлттэй бонд гаргахад өндөр шаардлага тавигддаг. Энэ нь тухайн компанийн үйл ажиллагаа хэр тогтвортой, нээлттэй байгааг шалгадаг. Харин бонд худалдаж авч байгаа хүмүүс манай компанийн мэдээлэл, тайлан тооцоог судалж хөрөнгө оруулалт хийж байгаа нь ирээдүйд хөгжих нь гэдэг итгэл үнэмшилтэй байгаагийн илрэл.

Манай компани хөрөнгийн захаас хөрөнгө оруулалтыг амжилттай татсан нь бидний өнөөдрийг хүртэл хичээж ажилласны үр дүн.



Түүнчлэн манай Анд группийн хэтийн зорилго олон улсын зах зээл. Тэгэхээр төрөлх нутагтаа төдийлөн сайн ажиллаж чадахгүй бол дэлхийн тавцанд гарахыг мөрөөдөх ч хэрэггүй. Тиймээс аль болох олон улсын стандартыг хэрэгжүүлж, илүү нээлттэй ажиллахыг эрхэмлэдэг.

Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал бий юу?

Манай компанийн онцлогийг харвал нэг талаасаа хөрөнгийн бирж болон санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай хувьцаат компани нөгөө талаасаа старт-апп компани шүү дээ. Нэг талаас нь харахаар старт-апп учраас аливаа зүйлийг шийдвэрлэхэд хурд чухал. Харин нээлттэй компанийн хувьд бүхий л шийдвэр шат дараагаар явах учиртай байдаг. Тэгэхээр энэ хоёрыг зохицуулах зайлшгүй шаардлага тулгардаг. Аль хэсэгтээ гарааны бизнесийн зарчмаар шийдвэр гаргаж, аль хэсэгтээ нээлттэй компанийн жишгээр ажиллах ёстой вэ гэдгийг зөв тодорхойлох хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн шийдвэрийг хурдтай гаргах ёстой учраас хурд, уян хатан байх зарчмыг баримталж байна. Засаглалын тухайд байгууллагын үйл ажиллагаа, хөгжлийг нээлттэй компанийн зарчмаар авч явна.

Компаниудад ажиллах хүч дутмаг байгаа нь гүйцэтгэх удирдлагуудын “толгойн өвчин” болдог. Ялангуяа технологийн дэвшлийг ашиглан үйл ажиллагаа явуулдаг компанийн ажиллах хүчний хүрэлцээ ямар байна вэ?

Технологийн систем хөгжүүлэлтийг “Анд системс” компаниас авдаг. Ингэснээр системийг хөгжүүлэхэд гадна талаас хамаарах зүйлгүйгээр маш хурдтай ажиллах боломжтой нь бидний давуу тал.

Ер нь мэргэжлийн боловсон хүчин дутмаг байгаа нь үнэн. Учир нь сургууль төгссөн оюутан ажлын талбарт гараад ажил олгогчийн шаардлагад нийцэж ажиллана гэдэг хугацаа шаарддаг. Тиймээс хувь хүний сурах чадвар маш чухал.

Манай групп дэлхийн зах зээлд гарах зорилготой учраас тэр хэрээр чадварлаг, туршлагатай боловсон хүчнийг авч ажиллуулахад анхаардаг.

Олон нийтийн санхүүгийн боловсролд чиглэсэн ямар ажил хийж байна вэ?

Хүмүүс мөнгө хадгалж эхэлснээр тодорхой хэмжээнд санхүүгийн боловсролд суралцаж байдаг. Тиймээс хадгаламж анхан шат гэвэл дараагийн шат нь үр өгөөжтэй хөрөнгө оруулалт байх юм. Тэгэхээр богино болон дунд хугацаанд ашиг хүртэхийг хүсэж байгаа бол бонд худалдаж авах, харин урт хугацаанд үр өгөөж хүртэнэ гэвэл хувьцаа авч болно гэх мэтээр санхүүгийн боловсрол олгох мэдээллийг өөрсдийнхөө хэмжээнд олон нийтэд хүргэхээр хичээн ажиллаж байгаа.

Энэ жил танайх шинэ бонд гаргасан шүү дээ. Хүмүүсийн хандлага ямар байна?

“ЛэндМН” энэ жил 2 дахь удаагаа нээлттэй бонд гаргалаа. Энэ удаа бондоо илүү олон хөрөнгө оруулагчид хүргэхээр зорьсон. Нэгж үнэ нь 100 мянган төгрөг гэж тогтоосноор бондын хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Мэдээллийн хувьд энэ жил харьцангуй олон сувгаар хүргэж 505 хөрөнгө оруулагч хөрөнгө оруулсан юм. Цаашид энэ талаар мэдээллийг түлхүү хүргэх нь зүйтэй юм байна гэж харсан.

Манай улс эдийн засгаа солонгоруулж экспортын шинэ бүтээгдэхүүнтэй болохыг зорьж байгаа. Гэвч төдийлөн оновчтой шийдэл гаргаж, үр дүнд хүрэхгүй байна гэж хардаг?

Бидний гаргаж байгаа бүтээгдэхүүн хэр том орон зайг эзэлж байгаа вэ гэдэг хамгийн чухал. Хэдийгээр манай улс ноолууран бүтээгдэхүүнээ эцсийн бүтээгдэхүүн болгон гаргаж байгаа ч зарим нэг шинэчлэл, дэвшлийг нэвтрүүлэх, хийх шаардлагатай гэж хардаг.

Монгол хүний оюун ухааныг ашиглан дэлхийн мэдээллийн технологийн салбарт гарах боломж нээлттэй байна. Тухайлбал, манай улсын хөгжүүлэгчид эх орноосоо гадны томоохон компаниудад ажиллаж байна шүү дээ. Тэгэхээр эдийн засгийг солонгоруулахад дэлхийд мэдлэг экспортлох боломж мэдээллийн технологийн салбарт бий гэж хардаг.

ФИНТЕК ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТЭД НӨЛӨӨЛӨХ НЬ

Өмнөх дугааруудад хүргэж байснаар Тогтвортой хөгжлийн зорилт, Парисын хэлэлцээрийн дагуу тэгш, шударга, хүртээмжтэй нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжилд хүрэх хамгийн том хөшүүрэг нь санхүүжилтээр дамжуулан үйлдвэрлэл эрхлэгч, үйлчилгээ хүргэгчдийн үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд ээлтэй болгоход нөлөөлөх байдаг. Өнөөгийн нийгэм, эдийн засагт тулгараад буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх хамгийн том гарц нь санхүүгийн зах зээл дэх **тогтвортой санхүүжилт** ба түүнийг хурдасгах, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гол хэрэгсэл **финтек** болоод байна.

Финтек болон дижитал санхүүжилт нь тогтвортой санхүүжилттэй шууд холбогдохгүй хэдий ч, судлаачид тэдгээрийн уялдаа холбоог судалсаар байна.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад ядуурлыг тэглэх, усан доорх амьдрал, хөрсөн дээрх амьдралыг хамгаалах зэрэг байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх бүхий л зорилгуудыг дэвшүүлсэн нь санхүүгийн хүртээмж, тогтвортой санхүүжилтээр дамжин шийдэгдэх юм. Орчин үед санхүүгийн хүртээмжийг хамгийн хурдацтайгаар нэмэгдүүлж байгаа зүйл нь санхүүгийн технологи буюу финтек болоод байна.

Санхүүгийн хүртээмж яагаад чухал вэ?

Санхүүгийн үйлчилгээг нийгмийн бүх хэсэгт зардал багатайгаар хүргэх нь санхүүгийн хүртээмжийн салшгүй нэг хэсэг. Ингэснээр хүмүүс санхүүгээ үр ашигтайгаар удирдах боломжийг бий болгохоос гадна цаашлаад ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг дэмждэг.

Хувь хүмүүсийн эмзэг байдлыг бууруулах: Хүмүүст хуримтлал, хадгаламжийн үйлчилгээг хүргэснээр боловсрол, эрүүл мэнд, бичил бизнестээ хөрөнгө оруулах, гэнэтийн эрсдэлийг даван туулах боломжийг олгодог; **өдөр тутмын**

амьдралын үр ашгийг дээшлүүлэх: Төлбөр тооцоо, санхүүгийн бусад үйлчилгээг цаг алдалгүй цахим хэлбэрээр гүйцэтгэх боломжтой; **санхүүгийн системээр дамжуулан эрсдэлээ тархаан байршуулах:** Тэжээгчээ алдсаны тэтгэмж, даатгал нь хүмүүсийг буцаж ядуурлын тойрогт орохоос сэргийлэх; **бодит эдийн засгийн үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлтийг бий болгох:** Иргэд, жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд санхүүгийн хүртээмж нь чухал нөлөөтэй. Санхүүгийн хүртээмжтэй байдал нь өвчин, гэмт хэрэг, ядуурал, ажилгүйдэл гэх мэт асуудлуудыг бууруулах, эдгээрээс үүсэх эрсдэлийг удирдах нэг арга юм. Жишээлбэл, тариачид цахим төлбөрийн үйлчилгээг авснаар хулгайд санаа зовохоо болих; эрүүл мэндийн даатгалд хамрагдах нь урт хугацаанд ажиллах боломжийг олгох; хүүхдийнхээ боловсролыг санхүүжүүлэхээр хуримтлал, хадгаламж үүсгэх гэх мэт урт хугацааны зорилтуудад хүрэх боломжтой.


Дижитал санхүү болон финтек нь тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд дараах байдлаар дэмжлэг үзүүлдэг:

Санхүүгийн нөөцийн хуваарилалтыг сайжруулснаар тогтвортой хөгжлийг дэмжих. Жишээ: ESG /байгаль орчин, нийгэм, засаглал/-ын болон Ногоон хөрөнгө оруулалтын стратегиуд;

Санхүүгийн систем дэх нөөцийг нэмэгдүүлж, Тогтвортой хөгжлийн зорилтуудад ашиглах. Санхүүгийн салбарыг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлснээр хөгжиж буй орнуудын санхүүгийн эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой болно. Жишээ: БНХАУ-ын дижитал санхүүгийн шилжилт;

Дижитал санхүү, финтекийг тус зорилтуудыг дэмжихэд шууд ашиглах. Санхүүгийн болон зохицуулалтын шинэ технологийг системд нэвтрүүлснээр тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих боломжтой.

FINTECH



Хүснэгт 1. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад үзүүлэх финтекийн нөлөө

	Зорилтууд	Нөлөөлөл	Финтекээр дамжуулж санхүүгийн хүртээмжийг дээшлүүлснээр үзүүлэх нөлөө
1	Ядуурлыг тэглэх	Шууд бус	Зээл, хамтын санхүүжилт зэрэг онлайн санхүүжилт хийх боломжийг олгох, цахим төлбөр тооцоо, зах зээлийг хөгжүүлснээр нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгох
2	Өлсгөлөнг зогсоох	Шууд бус	Санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, хадгалах, зээлэх зэрэг арга хэрэгслүүдээр дамжуулан мөнгөний урсгалыг тогтворжуулах
3	Эрүүл мэндийг дэмжих	Шууд бус	Эрүүл мэндийн даатгал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд Засгийн газрын орлогыг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах
4	Чанартай боловсролыг дэмжих	Шууд бус	Санхүүгийн төлөвлөлтийг сайжруулах, сургуулийн төлбөрийг хэмнэх, боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд Засгийн газрын алдагдлыг бууруулж, орлогыг нэмэгдүүлэх
5	Жендерийн эрх тэгш байдлыг хангах	Шууд	Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих, тэдгээрийн санхүүгийн хүртээмжийг сайжруулах
6-7	Ус, сэргээгдэх эрчим хүч	Шууд бус	Дэд бүтцийг хөгжүүлэх болон засварлах санхүүжилтийг бий болгох, орон нутгийн тогтвортой байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх
8	Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих	Шууд	Зээл, хамтын санхүүжилт зэрэг онлайн санхүүжилт хийх боломжийг олгох, цахим төлбөр тооцоо, зах зээлийг хөгжүүлснээр нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгох
9	Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх	Шууд	Дэд бүтцийг хөгжүүлэх, засварлахад зориулж санхүүжилт олгох, Засгийн газрын орлогыг нэмэгдүүлж, алдагдлыг бууруулснаар дэд бүтэц, судалгаа, шинжилгээний санхүүжилтийг сайжруулах
10	Тэгш бус байдлыг бууруулах	Шууд	Боловсрол, санхүүгийн хуримтлалын санхүүжилтийг нэмэгдүүлэх
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	Шууд бус	Тогтвортой технологи, өөрчлөлтийг хөгжүүлэх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүлдэг
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	Шууд бус	Тогтвортой технологи, өөрчлөлтийг хөгжүүлэх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүлдэг
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	Шууд бус	Тогтвортой технологи, өөрчлөлтийг хөгжүүлэх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүлдэг
14	Далай тэнгисийн нөөцийг хамгаалах	Шууд бус	Тогтвортой технологи, өөрчлөлтийг хөгжүүлэх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүлдэг
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	Шууд бус	Тогтвортой технологи, өөрчлөлтийг хөгжүүлэх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүлдэг
16	Энх тайван шударга ёсыг цогцлоох	Шууд бус	Засаглал, институц, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх асуудлаар Засгийн газрын орлогыг нэмэгдүүлж, алдагдлыг бууруулах
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	Шууд	Санхүүгийн технологийг хөгжүүлснээр оролцогч талуудын туслалцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

Эх сурвалж: Люксембургийн их сургууль

Дээр дурдсанчлан технологийн дэвшлийн хэд хэдэн хувилбарууд тогтвортой санхүүжилтэд ашиглагдаж байна. Тухайлбал, хиймэл оюун ухааныг үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаас тогтвортой байдлын хэмжүүрийг хянахад ашиглаж байна. Ингэснээр мэдээлэл олж авах хугацаа болон зардлыг бууруулж, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжсэн шийдлийг бий болгосон. Тогтвортой санхүүжилтийг хурдасгах, хүртээмжтэй болгоход дараах 3 төрлийн дижитал санхүүжилтийн хэлбэр хэрэгжиж эхэлсэн ба үүнд хамтын санхүүжилт, блокчэйн технологи, хиймэл оюун ухаан ба их өгөгдлийн шинжилгээ хамаарна.

Кларити (clarity) хиймэл оюун ухаан: Уг технологийн компани нь 2017 онд байгуулагдсан бөгөөд нийгмийн

нөлөөллийн зэрэглэл тогтоодог, хөрөнгө оруулалтын багцын байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийдэг. Хөрөнгө оруулагчдад 1000 гаруй үзүүлэлтийг ашиглан 198 улсын 30,000 гаруй компани, 187 орон нутгийн засаг захиргааны байгууллага болон 200 гаруй хөрөнгө оруулалтын сангийн байгаль орчны нөлөө, тогтвортой байдлыг үнэлэхэд их өгөгдөл болон машин сургалтыг ашиглан технологид суурилан багцаа үнэлэх боломжийг санал болгодог. Уг шийдэл нь хөрөнгө оруулагчдын байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийх найдваргүй, хязгаарлагдмал мэдээллийн улмаас мэдээлэл олж авах зардлыг ихэсгэдэг асуудлыг технологийн дэвшлээр шийдсэн. Кларити хиймэл оюун ухаан нь санхүүгийн гүйцэтгэлийг хамгийн их, байгаль

орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах хувилбарыг санал болгодог.

Пенсумо (Pensumo): Пенсумо нь өдөр тутмын зарцуулалтаар дамжуулан хувийн тэтгэврийн даатгалын төлөвлөгөөнд хувь нэмрээ оруулах зорилготой Испани Улсад үйл ажиллагаагаа явуулдаг.

Хэрэглэгчид аппликэйшн татаж авснаар дэлгүүр явах, спорт, соёлын үйл ажиллагаа, аюулгүй байдал, сайн дурын үйл ажиллагаа зэрэг өдөр тутмын ажиллагаануудаа оруулна. Ингэснээр тэдний тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй худалдан авалтууд тооцогддог ба түүнд нь үндэслэн хадгаламж хийгдэнэ. Тогтвортой үйл ажиллагаанд хувь нэмэр оруулсан хэрэглэгчдэд хадгаламж үүсдэг ба тэдгээрийн хадгалагдсан мөнгийг Аллианз даатгалын компани удирддаг.

Пенсумогийн маш олон үйл ажиллагаа хойч үеийнхний нөөцийг хорогдуулалгүйгээр тогтвортой хөгжилд чиглэж байна. Жишээлбэл орон нутгийн дэлгүүр рүү дугуйгаар худалдан авалт хийхээр явах нь тогтвортой хөгжлийн төлөөх үйл ажиллагаа юм. Үүний үр дүнд тээврийн хэрэгслийн хэрэглээ, түлшний зарцуулалт, хүлэмжийн хийн бохирдлын хэмжээ буурч байгааг онцолжээ.

Ёс зүйтэй хадгаламж, нийгмийн хариуцлагатай хөрөнгө

оруулалт, дахин ангилалт нь эдийн засагт нийтлэг болж байна. Тиймээс Пенсумо нь хэрэглэгч болон компанийн хооронд коммунити үүсгэж, хэрэглэгчдийн хадгалах зуршил, тогтвортой хөгжлийн төлөөх үйл ажиллагааг идэвхжүүлсэн.

Нийлүүлэлтийн гинжин хэлхээний ил тод байдал: Блокчэйн технологийг уул уурхай болон хөдөө, аж ахуйн салбарын гадаад худалдаанд ашиглаж, зардал бууруулах зорилго тавьсан.

Ногоон финтек: Ант санхүүгийн үйлчилгээ буюу БНХАУ-ын Алипэй компаниар танигдсан уг финтек компани нь хэрэглэгчдийнхээ хүлэмжийн хийн ул мөрийг багасгахыг дэмжиж 1) хүмүүсийн ухаалаг утсанд хүлэмжийн хийн ялгарлын мэдээг хүргэх 2) хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгод тэдний ногоон энергийн статус, виртуал тодорхойлолтыг холбох 3) мод тарих хөтөлбөрөөр дамжуулан хүлэмжийн хийн ялгарлыг тэнцвэржүүлэх. Уг үйлчилгээг санал болгосноор хэрэглэгчдийн тоо хүлээлтээс давсан ба ихээхэн хэмжээний зан төлөвийн өөрчлөлт гарсан. Тухайлбал 150,000 тн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, 1 сая гаруй мод тарьсан байна.





ӨРИЙН УРХИ ГЭЖ ЮУ ВЭ?

Өрийн урхи гэдэг нь: Зээл, хүүгийн төлбөрөө барагдуулж чадахгүй нөхцөл байдалд орохыг хэлдэг. Олон дахин зээл авах нь өрийн урхинд орох магадлалыг нэмэгдүүлдэг ба төдийлөн анзаарагддаггүй.

Та 4 болон түүнээс дээш асуултад **"ТИЙМ"** гэж хариулсан бол хувийн болон өрхийн санхүүдээ **АНХААРАХ ЦАГ БОЛСНЫГ ИЛТГЭНЭ.**

- 1 Та байнгын хэрэгцээндээ зориулж зээл авдаг уу?
- 2 Хэрэглээний төлбөрөө хугацаа хэтрүүлэн төлдөг үү?
- 3 Таны сар бүрийн тогтмол зардал, орлогын эх үүсвэрийн тань 50 хувиас их байдаг уу?
- 4 Кредит картын эргэн төлөлтөө хугацаа хэтрүүлэн хийдэг үү?
- 5 Та зээлээ төлөхийн тулд дахин зээл авдаг уу?
- 6 Ирээдүйн орлогоо барьцаалан зээл авдаг уу?
- 7 Сар бүрийн тогтмол зардлууд тань нэмэгдэж байна уу?
- 8 Та кредит картаар байнгын хэрэгцээгээ хангадаг уу?
- 9 Өөрт байгаа техникийн хэрэгслээ сайжруулах зорилгоор зээл авдаг уу?
- 10 Банк таны зээлийн хүсэлтээс татгалзаж байсан уу?



Өрийн урхинд орсноор...

Хэрэглээ
хумигдана

Хуримтлал
үүсгэх чадамж
бүцрнэ

Тэнэтийн цег
дахин зээл авах
боломжгүй болно

Сэтгэл
санааны
дарамт үүснэ

Зээлээ төлж
чадахгүй
болно



ӨРИЙН УРХИНААС ХЭРХЭН АНГИЖРАХ ВЭ?

Аливаа зээлийг төлж барагдуулах, санхүүгийн тогтворгүй байдлаас гарахад нөлөөлөх чухал хүчин зүйл бол сайтар тооцоолсон төлөвлөгөө ба санхүүгийн сахилга бат юм.



Зээлийн эргэн төлөлтийн график байгуулж сурах

Орлого болон зардлуудаа жагсаан бичих, хянах /Гар утасны платформууд/

Нэмэлт орлогын эх үүсвэртэй болж, зээлээ урьдчилан төлөх төлөвлөгөө гаргах

Өндөр хүүтэй зээлээ хамгийн эхэнд төлж барагдуулах

Нэмэлт зээл авахаас зайлсхийх

ӨРИЙН УРХИНААС АНГИЖРАХ АРГУУД



Зээлийн эргэн төлөлтийг заасан хугацаанаас хэтрүүлэхгүй байх /Цалингийн данстай холбох/

Олон тооны жижиг зээлтэй бол нэгтгэх

Аливаа өвчин, бэртэл гэмтлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх

Гэнэтийн хэрэгцээнд зориулсан хувийн санхүүгийн төлөвлөгөө гаргах

Зээлийн хугацаагаа сунгахгүй байх

ХЭРЭГЛЭГЧ

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан санал, дүгнэлт гаргаж хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2021 оны 2 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр нийт 274 өргөдөл ирсэн бөгөөд үүний 180 нь цаасаар, 94 нь цахимаар ирсэн байв.

Үүнээс 162 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 18 өргөдөл гомдол хянах шатанд явж байна.

Хүснэгт. Нийт өргөдлийн тоо (улирлаар)

№	Салбар	2020/II	2021/II
1	Даатгал	61	33
2	Үнэт цаас	33	28
3	Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/	36	18
4	Хадгаламж, зээлийн хоршоо /ХЗХ/	3	3
	Нийт	133	82

Өргөдөл, гомдлын утга болон бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар нийт 499 өргөдөл, гомдол, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 98 өргөдөл, 2021 оны 2 дугаар улиралд цахимаар 94 өргөдөл ирснээс үнэт цаастай холбоотой 40, даатгал 2, ББСБ 20, ХЗХ 4, зохицуулалтад хамааралгүй 17 гомдол ирснийг ирснээс тухай бүрд нь хариу өгч ажилласан. Мөн цаасаар нийт 82 өргөдөл, гомдол тус тус ирсэн байна.

Салбарын үзүүлэлтүүд: Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Санхүүгийн зохицуулах хороонд хандаж, 2020 он, 2021 оны 2 дугаар улиралд цаасан хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

Санхүүгийн зохицуулах хороонд 2021 оны 2 дугаар улиралд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд өргөдөл гомдлын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад даатгал 45.9 хувь, үнэт цаас 15.2 хувь, банк бус санхүүгийн байгууллага 50.0 хувиар буурсан бол хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл хэвээр байна.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2020 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой нийт 130 өргөдөл ирснээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 123, хуулийн хугацаанд хянагдаж байгаа 7 өргөдөл, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 21 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 9, хуулийн хугацаанд хянагдаж байгаа 12 өргөдөл, гомдол байна.

Дээрх өргөдлүүдийн 14.2 хувийг эзэмшигчийн зөвшөөрөлгүй арилжаалагдсан хувьцаатай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байгаа бөгөөд эдгээрийг өмнө нь Үнэт цаасны хороо /хуучнаар/ –ноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон брокер, дилерийн компаниудаар дамжуулан арилжаалсан байна. Хувьцааны бүртгэл, дансны мэдээлэл шалгуулахаар 21.4 хувь, Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг 17.9 хувь, Хөрөнгө оруулалтын сан 10.7 хувийг тус тус эзэлж байна.

ДААТГАЛЫН САЛБАР

2020 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотойгоор өссөн дүнгээр нийт 269 өргөдөл ирснээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 262, хуулийн хугацаанд хянагдаж байгаа 7 өргөдөл, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар иргэн, хуулийн этгээдээс даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 59

өргөдөл, гомдол ирснээс 51 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 8 өргөдөл, гомдол хянагдаж, 2021 оны 2 дугаар улирлын байдлаар 33 өргөдөл ирснээс 27 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 6 өргөдөл хянагдах шатанд байна.

Санхүүгийн зохицуулах хороонд 2020 онд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, 93 даатгуулагчийн нөхөн төлбөрт нийт 1,557.6 сая төгрөгийг олгуулахаар шийдвэрлэж, үүнээс нэр бүхий 46 иргэн, хуулийн этгээдэд нийт 444.6 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон, 2021 онд өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, харилцагчийн хохирол барагдуулах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан даатгалтай холбоотой 21 иргэн, хуулийн этгээдэд 118,578,157 төгрөгийн нөхөн төлбөрийг олгохоор урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 6 иргэн, хуулийн этгээдэд 8,110,200 төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


2020 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 90 өргөдөл, гомдол, 2021 оны 1

дүгээр улирлын байдлаар нийт 15 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. 2021 оны 2 дугаар улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 18 өргөдөл, гомдол ирснээс 13 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж, 5 өргөдөл хянагдах шатанд байна.

Өмнөх улиралтай харьцуулбал, нийт өргөдлийн тоо 28.6 хувиар өссөн бол эдгээрийн 94.4 хувийг банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, зээлийн гэрээний маргаан, зээлийн мэдээллийн санд бүртгэсэн зээлийн ангилалтай холбоотой өсөлт бүхий маргаан эзэлжээ.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

2020 оны байдлаар ХЗХ-ны үйл ажиллагаатай холбогдуулан нийт 10 өргөдөл, гомдол, 2021 оны 1 дүгээр улиралд 3 өргөдөл, гомдол, 2021 оны 2 дугаар улиралд 3 өргөдөл, гомдол тус тус ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэжээ.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХИЙН ТУЛД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТЭРГҮҮНИЙ ЗОРИЛТ БАЙХ ЁСТОЙ ГЭЖ ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮЗЭЖ БАЙНА.

КОВИД–19 цар тахал нь корпорацууд болон хөрөнгийн зах зээлийн одоогийн бүтцийн сул талуудыг улам бүр дордуулав. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ЭЗХАХБ/-ын 2021 оны тайланд дурдсанаар энэ чиглэлээр үр дүнтэй бодлогын хариу арга хэмжээг яаралтай авахгүй бол хөрөнгө оруулалтын чадавх муутай компаниудын тоо өсөх, тэдгээрийн бараа материалын нөөцийн хэмжээ нэмэгдэж, хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг удаашруулах болно гэжээ.

Коронавируст халдварын хямралын дараах хөрөнгийн зах зээлд уг хямралыг даван туулахад дэмжлэг үзүүлэх, цаашид гарч болзошгүй элдэв цочролд тэсвэртэй байх явдлыг бэхжүүлэхийн тулд хөрөнгө оруулалт хийхэд ихээхэн хэмжээний санхүүгийн эх үүсвэр шаардлагатай. Чухамдаа компанийн засаглалын бодлого, хүрээг сайжруулснаар одоогоор биржид бүртгэлтэй болон шинээр бүртгүүлэх компаниуд шаардлагатай капиталгаа олон нийтээс татах боломжтой болно.

Цар тахалтай холбоотой хямрал эхэлснээс хойш бондын зах зээл компаниудын хувьд хөрөнгийн маш чухал эх үүсвэр байсаар ирсэн гэж тайланд дурдагджээ. Үүний үр дүнд аж ахуйн нэгжүүдийн бондын өрийн хэмжээ 2020 оны эцэст бараг 15.0 их наяд ам. долларт хүрч, түүхэн дээд хэмжээндээ хүрчээ.

Гэтэл дэлхий даяар аливаа өр нь ихэвчлэн төлбөр төлөх чадвар багатай аж ахуйн нэгжүүдэд хуримтлагддаг аж. Мөн хувьцааны зах зээл 2020 онд цөөн тооны томоохон компаниудад рекорд тогтоох их хэмжээний капитал босгох боломжийг олгожээ.

ЭЗХАХБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Матиас Корманн "Компанийн засаглал сайтай хөрөнгийн зах зээл нь Ковид–19 хямралаас гарах, эдийн засгаа сэргээхэд

чухал үүрэг гүйцэтгэнэ" гэжээ. Их20/ЭЗХАХБ-ын компанийн засаглалын зарчмууд нь энэхүү зорилтыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд бизнесийн салбарыг илүү динамик, өрсөлдөх чадвартай, ирээдүйд гарч болзошгүй цочролд тэсвэртэй болгоход тусална.

Хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд компанийн засаглалын хүчтэй тогтолцоо зайлшгүй шаардлагатай тул хямралын улмаас үүссэн бэрхшээлийг даван туулахын тулд бодлого боловсруулагчдын хувьд дөрвөн тэргүүлэх чиглэлийг тайланд онцолжээ. Үүнд:

- Эрүүл мэнд, нийлүүлэлтийн сүлжээ, хүрээлэн буй орчны эрсдэлийн менежмент, түүнчлэн аудитын чанар, өмчлөлийн төвлөрөл, компанийн төвөгтэй бүтэц зэрэг цар тахлын үед илэрсэн сул талуудыг арилгах үүднээс засаглалын тогтолцоог дахин тохируулах.
- Хөрөнгийн зах зээлийг улам нээлттэй болгох болон амьдрах чадвар бүхий корпорацуудын балансыг бэхжүүлэх, тогтвортой сэргэлт болоод урт хугацаанд уян хатан байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай бизнесийн шинэ загваруудыг бий болгоход туслах.
- Байгаль орчин, нийгэм болон засаглалын эрсдэлийн менежментийг сайжруулах, ялангуяа харьцуулж болохуйц, найдвартай мэдээллээр хангах цогц урсгалыг бий болгох.
- Компанийн төлбөрийн чадвар, үйл ажиллагааны уян хатан байдлыг дэмжих зорилгоор төлбөрийн чадваргүйдлийн тухай эрх зүйн дэглэм боловсруулах.



Эх сурвалж: OECD

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

- ◆ Японы *Fast Retailing* болон *Softbank*-ийн хувьцааны ханш тус тус 2 хувь унаснаар, *Nikkei 225* индекс 1.62 хувиар унаж, 27,523.19-д хүрэв.
- ◆ Германы *DAX* индекс түүхэндээ анх удаа 16,000 нэгжид хүрлээ

Япон улсын эдийн засаг 1.3 хувиар өсөж, судлаачдын таамаглалаас давав.

Тодруулбал, Япон улсын эдийн засаг өмнөх улирлаас 0.3 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 1.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

4–6 дугаар сарын хооронд Токио, Осака болон бусад бүс нутгуудад онц байдлын дэглэм зарласан ба энэ үед иргэдийн зардал өссөн нь эдийн засгийн уналтад орохоос сэргийлсэн байна. Мөн бизнесийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын зарцуулалт нэмэгдсэн нь эдийн засаг өсөхөд голчлон нөлөөлжээ.

Гэсэн ч Ковид–19–ын халдвараас хамааран өрхүүдийн нөхцөл байдал хүнд байгаа учир энэ оны сүүлийн хагас жилд эдийн засгийн хумигдах эрсдэлтэй гэж судлаачид үзэж байна.

АНУ–ын ДНБ өнгөрсөн оны мөн үеэс 6.5 хувиар өсжээ.

Одоогийн байдлаар АНУ–ын эдийн засаг цар тахлын өмнөх түвшиндээ эргэн очсон ба ДНБ–ий 70 орчим хувийг бүрдүүлдэг хэрэглээний зардал 11.8 хувиар өссөнөөр ДНБ өнгөрсөн оны мөн үеэс 6.5 хувиар өссөн байна.


ДНБ–ий өсөлтөд вакцинжуулалт, эдийн засгийн өргөн хүрээг хамарсан арга хэмжээнүүд үр нөлөөгөө үзүүлснээр АНУ–ын эдийн засаг 4 улирал дараалан өсөлттэй гарсан байна. Гэсэн ч эдийн засгийн өсөлтийн хурд найман хувиас дээш байх зах зээлийн таамаглалаас доогуур байгаа юм.

Ажиглагчдын үзэж буйгаар, Ковид–19 цар тахал нь эдийн засгийн тулгамдсан асуудал хэвээр байна. Олон компаниуд ажиллах хүчний хомсдолтой байгаагаас гадна Засгийн газар тусламжийн хөтөлбөрүүдээ зогсоосны улмаас сүүлийн хагас жилд хэрэглээний зардал буурах хандлагатай байгааг онцлов.

АНУ–ын нефтийн импорт, экспорт буурав.

АНУ–ын Эрчим хүчний мэдээллийн агентлаг /EIA/–аас нефтийн импорт, экспорт нь буурсан гэж мэдээлэв.

Нефтийн долоо хоногийн дундаж экспорт, импортын хэмжээ /сая торх/



Тодруулбал, АНУ–ын нефтийн импортын хэмжээ долоо хоногт дунджаар 6.4 сая торход хүрдэг бол 8 дугаар сарын 4 –ны байдлаар өмнөх долоо хоногоос 75 мянга орчим торхоор буурсан бол экспорт 1.9 сая торх болсон нь өмнөх долоо хоногоос 585 мянга торхоор буурсан байна.

АНУ нь сүүлийн жилүүдэд шатдаг занарын олборлолтоо нэмэгдүүлснээр нефть олборлогч томоохон орнуудын нэг болсон бол БНХАУ нь нефтийн хамгийн том импортлогчдын нэг болсон.

БНХАУ–ын нефтийн үнэ нэмэгдэж байна.

БНХАУ–ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооноос 2021 оны эхний хагас жилийн байдлаар тус улсын зах зээл дэх нефтийн үнэ өсөн удаа нэмэгдсэн гэж мэдээлжээ.

6 дугаар сарын сүүлээр 1 тонн шатахууны үнэ 225 юаниар, дизель 215 юаниар тус тус өссөн байна. Мөн эрчим хүчний зах зээлийн талаар мэдээлдэг “Oilchem.net”–ын шинжээчид дотоодын шатахуун, дизель түлшний үнэ цаашид 1 тонн нь 230 орчим юаниар буюу литр нь 0.17–0.20 юаниар нэмэгдэх магадлалтай ба цаашид ч өссөөр байна гэж үзжээ.

Алтны эрэлт нэмэгдэж, үнэ нь 4 өдөр дараалан өсөв.

8 дугаар сарын 14-нөөс 17-ны өдрийн хооронд алтны үнэ тасралтгүй өслөө. Улс орнуудын эдийн засгийн үзүүлэлтүүд тогтворгүй байж, Ковид-19-ийн "Дельта" хувилбарын халдвар эрчимтэй тархаж байгаатай холбоотойгоор эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл болох алтны эрэлт өссөн байна. БНХАУ-ын жижиглэн худалдааны борлуулалт, үйлдвэрлэлийн гарц шинжээчдийн хүлээлтээс доогуур байгааг онцолжээ.

Үүний зэрэгцээ АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж буурсан нь алтны үнэд дэмжлэг болсон байв. 8 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар алтны спот үнэ 0.02 хувиар өсөж, унц нь 1787.1 ам.доллар болоод байна.

Австралийн төв банк Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ авахад бэлэн гэдгээ мэдэгдэв.

Ковид-19 халдварт цар тахлаас хамааран эдийн засаг муудсаар байвал Австралийн төв банкны зүгээс бодлогын арга хэмжээ авахад бэлэн гэдгээ 8 дугаар сарын 17-ны өдөр илэрхийлсэн байна. Австрали долларын ханш 25

орчим хувиар буурч, 0.73 ам.долларт хүрсэн бол 10 жилийн хугацаатай бондын хүү 1.2 хувь болж, сүүлийн 7 сарын хамгийн доод түвшинд хүрсэн байв. Австралийн нөөцийн банкны Удирдах зөвлөл 8 дугаар сарын 03-ны өдөр хуралдаж, хөл хорио сулрах үед эдийн засаг сэргэнэ гэсэн эерэг таамаглалтай байгааг тодотгосон байна.

Лондонд төвтэй "HSBC" банк даатгалын салбарын "AXA Singapore"-ийг \$575 саяар худалдан авлаа.

Лондонд төвтэй "HSBC" Хөрөнгө оруулалтын банк "AXA Singapore" компанийг худалдан авахаар боллоо. Тус компани Сингапурын эрүүл мэндийн даатгалын салбарт тэргүүлдэг ба хэлцлийн нийт дүн 575 сая ам.доллар хүрч байгаа аж. Ингэснээр "HSBC" банк Зүүн Хойд Ази дахь тэлэлтээ түргэсгэлээ.

"HSBC" бусад бүс нутгууд дахь ашиггүй бизнесүүдээ зогсоохын зэрэгцээ Азийн орнуудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа юм. Тус банк Азийн бүс нутагт тус бүр 500 орчим сая ам.долларын 3-4 хэлцэл хийх боломжтой гэдгийг мэдэгдэж байсан юм.




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

S&P 500 /[^]GSPC/


4,509.37 +39.37 (+0.88%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /[^]N225/


27,789.29 +148.29 (+0.54%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /[^]FTSE/


7,148.01 +23.03 (0.32%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

15,129.50 +183.70 (+1.23%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia